

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бий болгох



Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг эн тэргүүнд тавих, өөрсдийнхөө эрхийг хамгаалахын төлөө бид дуу хоолойгоо гаргаж чадна.



Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд эрүүл байх, эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг авах эрхтэй. Гэтэл хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд очиж болох хэдхэн эрүүл мэндийн төв, эмнэлгүүд байдаг. Тэгээд бас тэдгээр газрууд нь хэтэрхий үнэтэй, эсвэл хэт хол байдаг тул та тэнд очиж үйлчлүүлэх, эмчилгээ үйлчилгээний төлбөр төлөх, эмийн үнэ төлөх, эсвэл эрүүл мэндийн ажилтнуудтай нь хэрхэн харилцах аргаа мэдэхгүй байх нь элбэг.

Бид энэ бүлэгт Дэлфини хэмээх бүсгүйн тухай, тэрээр өөрийн амьдардаг нутгийнхаа бусад эмэгтэйчүүдтэй хамт өөрт тохиолдсон эрүүл мэндийн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай түүхийг өгүүлэх болно. Дэлфини болон түүний найзууд түүнд тулгарсан асуудлын шийдлийг тухайн нөхцөл байдалд олж чадсанаараа энэ түүх онцлог юм. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд тулгардаг эрүүл мэндийн асуудал бол

бүх эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудал бөгөөд хэн нэгний эрүүл мэндийн асуудал ганцхан тэр хүний асуудал байдаггүй ТУХАЙН НИЙГМИЙН АСУУДАЛ байдаг. Дэлфини болон түүний найзуудын адил та ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй бусад эмэгтэйчүүдтэй хамтран нийгэмд байгаа эрүүл мэндийн асуудлын шалтгааны эх сурвалжийг олж түүнийг өөрчлөхийн төлөө ажилласнаар чанартай хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээг авч чадна.

Дэлфини-гийн түүх

Дэлфини тархины саажилттай учраас тэргэнцэрт суудаг ажээ. Түүнд найз залуу байдаг. Түүний найз залуу нь харанхуй болсоны дараа найз бүсгүй дээрээ ирж, өглөө нар мандахаас өмнө явдаг “Шөнийн ханхүү” нарын нэг байв. Түүний амраг өөрийгөө хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйтэй бэлгийн харьцаанд ордог гэдгийг хүмүүст мэдэгдэхийг хүсдэггүй байв.

Нэгэн өдөр бүсгүйн үтрээнээс хэвийн бус шингэн зүйл гарч эхлэв. Тэрээр ойролцоох эмийн санд хандан түүнийг эмчилж өгөхийг гуйсан боловч тус болсонгүй. Нөгөө шингэн нь бүр ихээр гарах болж түүний хэвлийгээр өвдөн биеийн байдал нь бүр дордож эхлэв. Сүүлд нь арга тасраад эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхээр болжээ. Гэтэл эмч нар түүнийг бэлгийн замын өвчин туссан байж магадгүй гэсэн өөрийнх нь таамаглалыг сонсохгүйгээр үл барам түүнд итгэхгүй байв. Дэлфини найз залуугаа дахин харж чадахгүй түүнд хаягдчих вий гэсэндээ түүний нэрийг хэлж чадсангүй.



Эмч нар бүсгүйн эрүүл мэндэд өөрчлөлт орсоныг нь хөгжлийн бэрхшээлтэй байдалтай нь холбон үзэж түүний хөл гарыг татаж чангаан булчин шөрмөс нь өөрчлөлттэй байгаа хэмээн оношилж булчин амрааж суллах эмчилгээ хийв. Гэвч өвчин намдаах эмчилгээ түүний хэвлийн өвдөлтөнд нөлөө үзүүлэхгүй улам ч дордуулж байв. Тэрээ халууран, хөлөрч, хөнгөнөөр бие засахад өвддөг болж эхлэв.

Тэр үед Дэлфини нэгэн найзынхаа ярьж байсан хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд өөр хоорондоо тэдэнд тохиолдсон эрүүл мэндийн асуудлыг ярилцдаг цуглааны талаар санан тэр газарт очиж өөрийнхөө байдлыг хэлэхээр шийдэв. Тэр цуглааны эмэгтэйчүүд “Эмчгүй газарт эмэгтэйчүүд яах вэ” нэртэй номыг судалдаг байжээ.

Тэр номонд халдвар бэлгийн замаар нэг хүнээс нөгөөд дамжиж болдог талаар уншсан тул хоёр эмэгтэй сайн дураараа Дэлфинитэй хамт дахиад эмнэлэг явахаар болов. Тэд нийлж байгаад Дэлфини бэлгийн харьцаанд орсон гэдгийг эмчид арай гэж үнэмшлүүлж чаджээ. Эмч шаардлагатай шинжилгээг хийж бүсгүйг бэлгийн замын аюултай өвчин туссан болохыг тогтоов. Түүний энэ бүх зовлон заг хүйтэн, хламид өвчнөөс үүдэлтэй болох нь илэрхий болов. (8-р бүлгээс үзнэ үү).

Эмч түүнд зохих эмчилгээг хийж эдгээв. Мөн түүний найз залуу ч бас эм уух ёстой, бас бэлгийн харьцаанд орохдоо бэлгэвч хэрэглэх юм бол дахин халдвар авахгүй гэж зөвлөжээ.


Асуудал үүссэн шалтгааны эх үүсвэрийг олох

Дэлфини эм ууж эрүүл мэндийн байдал нь сайжирсаны дараа түүний эрүүл мэндтэй холбоотой асуудал нь дуусгавар болсон гэдэгт итгэхийг хүсч байлаа. Гэтэл ном уншсаны дараа түүний бодож байгаа нь худлаа юм байна гэдгийг мэджээ. Хэрэв түүний найз залуу түүнтэй дахин уулзаад бэлгэвч хэрэглэхгүй, эм уухгүй юм бол дахиад л халдвар авна гэдгийг олж мэдэв.



Дэлфини өөрт тулгарсан асуудлыг бусад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдтэй ярилцав. Тэд ярилцаад “Гэхдээ яагаад...” гэдэг нэртэй тоглоом тоглосоноор асуудлыг үүсгэж байгаа нөхцлийг тодорхойлохоор шийдэв.





Энэ мэтээр эмэгтэйчүүд урт гэгчийн шалтгааны жагсаалт гарган түүнийгээ бүлэглэн ангилахаар болов. Эрүүл мэндийн асуудал үүсгэдэг олон төрлийн нөхцөл байдлыг ямар аргаар шийдвэрлэж болохыг ийм маягаар харах нь хялбар байв.

БИЕ БЯЛДРЫН ШАЛТГААН

- Заг хүйтний нянгууд
- Хламидын нянгууд
- Бэлгийн замаар халдвар авсан үед эмэгтэйчүүдийн бие махбод эрчүүдийнхээс илүү эмзэг байдаг. Ялангуяа үтрээ, эсвэл савны хүзүүнд шарх, улайлттай бол бүр эмзэг байдаг.
- Хүнс тэжээлийн хомсдол, олон удаагийн жирэмслэлт эмэгтэй хүнийг сулруулж өвчин тэсвэрлэх чадвар муутай болгодог.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТАЛААРХ БУРУУ ОЙЛГОЛТУУД

- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг “жинхэнэ” эмэгтэй гэж хардаггүй.
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд бэлгийн харьцаанд орж чадахгүй.
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд тулгардаг ихэнх эрүүл мэндийн асуудал нь түүнийг хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй гэж эмч нар итгэдэг.

НИЙГМИЙН ЕРӨНХИЙ ШАЛТГААН

- Эрчүүд сексийн өөр хамтрагчтай байх нь элбэг байдаг.
- Эрчүүд бэлгэвч хэрэглэхийг хүсдэггүй. Учир нь бэлгэвч хэрэглэх нь “эрэгтэйлэг бус” бөгөөд бэлгийн дур хүслийг гутаадаг.
- Бэлгийн замаар халдварлах өвчний талаарх эрүүл мэндийн боловсрол дутмаг.
- Эмэгтэй бэлгэвч үнэтэй бас ховор байдаг.
- хөгжлийн бэрхшээлтэй хамтрагчаасаа эрчүүд ичдэг.



Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ бол хүний эрхийн асуудал

Эрүүл мэндийн сайн тусламж үйлчилгээ авсанаар хөгжлийн бэрхшээлийг илүүтэй муутгадаг хүндрэлүүдээс урьдчилан сэргийлдэг. Түүнчлэн эрүүл мэндийн сайн тусламж үйлчилгээ авсанаар хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй эрүүл мэндийн хүндрэлүүдээс урьдчилан сэргийлж багахан хүндрэлийг цагийг нь олж эмчлэх

хэрэгтэй. Жишээ нь: нэг талаараа удаан суух эсвэл хэвтэх үед үүсдэг хүндрэлийг эмчлэх нь цооролт үүсэхийг зогсооно.

Бид хоол тэжээл, идэвхитэй хөдөлгөөн, нөхөн үржихүйн эрүүл мэнд, урьдчилан сэргийлэлт, эмчилгээний талаарх зөв зан үйлийг сурталчлах хэрэгтэй. Бас бид амьдралын буруу хэв маягаа өөрчлөх ёстой. Бидэнд өөрөө өөрийнхөө эрүүл мэндийг хамгаалах хүч чадал бий.



Тайландад бид улсын эмнэлэгт эрүүл мэндийн үйлчилгээ авахад 1\$ төлдөг.



Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нийгмийн байдлаас үл хамааран хөгжлийн бэрхшээлтэй бүх эмэгтэйчүүдэд хүртээмжтэй байх ёстой. Эрүүл мэндийн сайн тусламж үйлчилгээ гэдэгт үнэ төлбөргүй эсвэл бага төлбөртэй үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг төлөх даатгал, эсвэл эрүүл мэндийн сан хүртээмжтэй байх, нийтийн тээврийн хэрэгслээр зорчиход хялбар байх гэсэн

Энд гарсан булдруу нэг л аюултай санагдах юм. Гэлээ гээд би юу хийж чадах билээ дээ. Эм нь их үнэтэй, эмнэлэг хол байдаг. Аягүй бол хүмүүс намайг шоолох биз.

ойлголтуудыг хамааруулдаг. Энэ нь ялангуяа ядуу амьдралтай, эсвэл эрүүл мэндийн байгууллагаас алслагдсан газарт амьдардаг эмэгтэйчүүдэд маш чухал ач холбогдолтой.

Ядуурал ба эрүүл мэнд

Дэлхий нийтийг хамарсан худалдаа эдийн засгийн бодлого ядуурлыг бүр ихээр бий болгож улмаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрлийг цөөрүүлэн, хүмүүсийн нийгмийн ялгааг нэмэгдүүлж байна. Энэ тэгш бус байдал нь эрүүл мэндийн үйлчилгээг эмэгтэйчүүд өөрөө авахад нь, тэдний гэр бүлийнхэнд мөн адил дарамт учруулж байна. Эрүүл мэндийн үйлчилгээ авсаны төлбөр бол эрүүл мэндийн үйлчилгээний өөр нэг саад бэрхшээл болдог. Эмийн үнэ, унааны зардал гэх мэт санхүүгийн саадууд эрүүл мэндийн үйлчилгээг авах боломжгүй болгож байна.

Эдгээр нь хөгжлийн бэрхшээлтэй

эмэгтэйчүүдийг эрүүл мэндийн үйлчилгээ авахад нь хүнд болгодог. Жишээ нь: Африкийн ихэнх улсад хөгжлийн бэрхшээлтэй 100 хүн тутмын нэг нь л өөрт хэрэгцээтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авч чаддаг. Үйлчилгээ дутагдалтай байгаагаас гадна үйлчилгээний үнэ, эмнэлгийн алслагдсан байдал, бие махбодийн саад, хорт зуршил зэргийг нэмж хэлэх хэрэгтэй. Тухайн эмэгтэй мөнгөтэй байсан ч эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байдал нь хүртээмжгүй байдаг. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн хэрэгцээ болох нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээг хангах байдал маш дутагдалтай.

Үзлэгт хамрагдсаны давуу тал нь юу юм бэ? Үзлэг үнэгүй байсан ч эм нь үнэгүй байддаггүй. Манай гэр бүлийнхэн надад өөр эм өгч өгөх боломж байхгүй.



Нигерийн саадыг арилгасан нь

Экзетэ Жүдит Юмох нь полиогоор өвдсөн хүн бөгөөд Нигери улсын Нигер Делта гэдэг газрын тосоор баян мужаас гаралтай эмэгтэй. Өнөөдөр түүнийг “Түмний ээж” гэж дуудах хүмүүс ч байдаг. Энэхүү нэр нь хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлыг хөтөлбөрийн төлөвлөлт, үйлчилгээний шат бүрт хамруулсан нь түүний шаргуу зантай холбоотой. “Хаана хамгийн ихээр хөндүүрлэж байгааг тухайн гутлыг өмссөн эмэгтэй л мэддэг”, “Бид эмэгтэйчүүд, иймээс бусад эмэгтэйчүүдэд зориулагдсан нийгмийн үйлчилгээг бид ч бас авах эрхтэй” гэж Экзетэ хэлдэг. 2000 онд Экзетэ хөгжлийн бэрхшээлтэй тэр дундаа хүүхэд, эмэгтэйчүүд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эрх тэгш авахад чиглэсэн өрхөд суурилсан төвийг үүсгэн байгуулсан. Тэрээр “хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд ХДХВ/ДОХ-ын мэдээлэл өгөх, нөхөн үржихүйн эрүүл мэндийг тусламж үйлчилгээг хүртээмжтэй үзүүлэх зорилготой” “Эрүүл мэндийн саадгүй үйлчилгээ” төслийг хэрэгжүүлсэн. Бид хараагүй эмэгтэйчүүдэд зориулан нөхөн үржихүйн эрүүл мэндийн энгийн мэдээллийг Брайль дээр хөрвүүлэх ажил хийж байгаа. Мөн бид сар бүр бэлгийн боловсрол, түүнтэй холбоотой жирэмслэлт, эцэг эх болох болон хөгжлийн бэрхшээлийн талаар ярилцдаг уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулдаг”.

Бид эмэгтэйчүүд, иймээс бусад эмэгтэйчүүдэд зориулагдсан нийгмийн үйлчилгээг бас авах эрхтэй



Өрхөд суурилсан нийгмийн халамж шаардсан хүмүүсийн төлөөх ТББ нь эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлаарх өргөн цар хүрээтэй боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг. Мөн гэр бүлийн эрүүл мэндийн нийгэмлэгтэй хамтран ажилладаг. “Гэр бүлийн эрүүл мэндийн нийгэмлэг нь хүн амын хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн мэдлэгийг дээшлүүлэх эрүүл мэндийн чиглэлийн сургалт, семинартаа биднийг оролцохыг зөвшөөрсөн” хэмээн Экзетэ бидэнд ярьсан. Дээрх 2 байгууллага хамтран сургалт зохион байгуулахаар бол бүх эмэгтэйчүүдэд хүртээмжтэй байх нөхцөлд илүүтэй анхаарал

хандуулдаг байна. Тухайлбал: тэргэнцэртэй эмэгтэйчүүдэд хүртээмжтэй байх үүднээс байр маань тохиромжтой эсэх, сонсголын хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд оролцох боломжийг бүрдүүлж дохионы хэлтэй орчуулагч байлгах зэрэгт анхаарал хандуулдаг байна. Өрхөд суурилсан эрүүл мэндийн нийгэмлэгийн сургалтанд хамрагдсанаар хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд өөрийн орон нутгийнхаа гэр бүлийн эрүүл мэндийн боловсрол олгогч сургагч багш болдог байна. Экзетэ болон түүний хамтрагчид Засгийн газар, Олон талт байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудад хөгжлийн бүх ажилдаа “хөгжлийн бэрхшээлийн дуран” -г ашиглаж эхлэхийг уриалсан. Тэд олон газарт энэхүү саналаа хүргүүлжээ. Жишээ нь: Дэлхийн банк хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чиглэсэн сургалт, техникийн дэмжлэг, зөвлөгөө, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлсэн нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, тэдний хэрэгцээ үргэлж Дэлхийн банкны анхааралд байдаг, тэднийг мартаагүй гэдгийг баталж байгаа юм. “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хаа сайгүй байдаг, тэд нийгэмд амьдарч байгаа бусад иргэний эдэлдэг эрх дархыг мөн адил эдлэх эрхтэй” гэдгийг Экзетэ бидэнд сануулж өгсөн.

Эрүүл мэндийн үйлчилгээг авахад хялбар болгох

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, эрүүл мэндийн ажилтнуудтай хамтран эрүүл мэндийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд ээлтэй болгож чадна. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд эрүүл мэндийн төвүүдэд саадгүй очих, тоног төхөөрөмжүүдийг ашиглах, эмнэлэгийн ажилтнуудын хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдтэй харьцах харилцаа хандлагыг сайжруулах арга замыг тэд хамтдаа хийж чадна. Дээр дурьдсан өөрчлөлтүүдийн ихэнх нь хэрэгжүүлэхэд хэцүү биш, хөрөнгө санхүүжилт нэг их шаардахгүй юм.

Эдгээр өөрчлөлтийг хийж чадвал өөр бусад олон хүнд тустай. Залуу насны эрч нь саарч хөдлөхөд бэрхшээлтэй болсон ахмадууд, осол гэмтэлд өртөөд хөл гар нь хугаран түр хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдсан хүмүүст ч мөн адил тустай болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл мэндийн үйлчилгээг ээлтэй болгох санаанууд

- Эрүүл мэндийн төвөөс хол амьдардаг хүмүүст 7 хоногт нэг удаа, эсвэл сард нэг удаа гэрийн эргэлт авах
- Эрүүл мэндийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд үнэ төлбөргүй хийх
- Тоног төхөөрөмжүүдийг ашиглахад хялбар болгох
- Нийтийн болон хувийн тээврийн хэрэгслийг эрүүл мэндийн төвүүд рүү очдог буудалтай болгох. Гэхдээ үйлчилгээнд явж буй тээврийн хэрэгслүүд алхаж чаддаггүй, суга таягтай, тэргэнцэртэй хүмүүст ээлтэй байх ёстой. Хүртээмжтэй байдлын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл 376-р хуудасны Илүү мэдэхийг хүсвэл гэсэн хэсгээс үзнэ үү.

Эрүүл мэндийн үйлчилгээ авахад тулгардаг бэрхшээлүүд

- Ихэнх эрүүл мэндийн төвд ороход тэргэнцэртэй, эсвэл таягтай эмэгтэйчүүдэд үүдээр нь орохоос эхлээд их хүнд байдаг. Учир нь эрүүл мэндийн төвөөс хол, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй ганцаараа хүрэх газартаа очих гэхээр тэдэнд тохирох тээврийн хэрэгсэл байдаггүй зэргээс шалтгаалдаг.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохиромжтой тоног төхөөрөмж, хэрэгслүүд (намхан ор, сайн чанарын катетер г.м) бараг байдаггүй.
- Эрүүл мэндийн төвүүдийн ажиллах цагийн хуваарь бусдын дэмжлэг шаарддаг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохиромжтой бус байдаг.
- Ихэнх эмэгтэйчүүд эрэгтэй эмчид үзүүлэхдээ мэгдэн сандардаг.
- Эрүүл мэндийн ажилтнууд сонсголын бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй хэл нэвтрэлцэж чаддаггүй. Мөн хараагүй үйлчлүүлэгчид зориулсан эрүүл мэндийн мэдээллийн гарын авлага байдаггүй.
- Эмч сувилагч болон бусад эрүүл мэндийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлийн талаар тэр бүр мэддэггүй, эсвэл сайн сургагдаагүй байдаг. Тэд хөгжлийн бэрхшээлийн талаар ташаа ойлголттой байх боломжтой тул таныг сонсохгүй байх талтай.
- Эрүүл мэндийн үйлчилгээ өртөг ихтэй, мөн та эрүүл мэндийн ажилтантай уулзахын тулд хэн нэгний гарыг цайлгах хэрэг ч гарч магадгүй (хээл хахууль).

Ихэнх эрүүл мэндийн ажилтнууд биднийг сонсдоггүй. Яагаад гэвэл тэд биднийг хэрэггүй амьтад гэж боддог. Аз таареал үзлэгт орж, шинжилгээ хийлгэдэг ч бидэнтэй харьцахгүй чимээгүйхэн ажлаа хийдэг. Хэрэв ямар нэгэн асуулт таавбал бидэн рүү зүгээр л хашгирдаг.



Эмнэлэг, эрүүл мэндийн газруудыг үйлчлүүлэгчдэд ойр болгох саналууд

Эмнэлэг, эрүүл мэндийн газрууд дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- ☐ Унаа очдог байршил байх
- ☐ Алхахад хүндрэлтэй, таягтай, тэргэнцэртэй хүмүүс ороход тохиромжтой байх.
- ☐ Налуу болон цахилгаан шаттай байх.
- ☐ Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд хэрэглэхэд тохиромжтой бие засах газартай байх.

Эмнэлэг, эрүүл мэндийн газрууд хараагүй, дүлий, эсвэл эмнэлэгт юу болж байгааг ойлгохдоо тааруу тархины саажилттай, оюуны хомсдолтой эмэгтэйчүүдтэй харилцах ажилтанг сургаж авах ёстой.

Эмнэлэг, эрүүл мэндийн газрууд дараах зүйлсийг хийх боломжтой:

- Албан хаагчдыг хөгжлийн бэрхшээлийн талаарх сургалтанд хамруулах.
- Эмнэлэгт ажилладаг хөгжлийн бэрхшээлтэй эрүүл мэндийн ажилтан, албан хаагчдыг хамруулах
- Харааны бэрхшээлтэй эсвэл сайн харж чаддаггүй хүмүүс барилга дотор явахдаа аюулгүй замаа олох боломжтой болгохын тулд байгууламжийг тойруулан бариул, эсвэл олс татах
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд болон эрүүл мэндийн сэдэвтэй үйл ажиллагаа зохион байгуулах.
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх ажлыг сар бүр, эсвэл тогтсон давтамжтайгаар зохион байгуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд өөр өөр тасагт үйлчлүүлэх хэрэгцээ гарахад өөр өөр өдөрт цаг авахыг нь аль болох хялбаршуулж эмнэлэгт очсон нэг өдөртөө авах ёстой бүх үйлчилгээнүүдээ авдаг болгох. Зарим эрүүл мэндийн төвүүд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд шаардлагатай үйлчилгээний цагийг тосгоны эрүүл мэндийн ажилтан өмнөөс нь эмчтэй тохирохыг зөвшөөрдөг
- Эрүүл мэндийн үйлчилгээг хэрхэн чирэгдэлгүйгээр авах тухай мэдээллийг гаргах
- Эрүүл мэндийн мэдээллийг өөр өөр хэл дээр гарган тараах
- Харааны бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн мэдээллийг Брайль хэл дээр эсвэл аудио хуурцагт буулгах
- Оюуны хомсдолтой эмэгтэйчүүдэд юу хэлэхийг хүсч байгаагаа энгийнээр, ойлгомжтой үг хэллэг ашиглан зурагтайгаар тайлбарлан үзүүлэхийг хөхүүлэн дэмжих
- Ярьж чаддаггүй эмэгтэйчүүдтэй нэвтрэлцэхэд эрүүл мэндийн ажилтнуудыг сургах
- Эрүүл мэндийн ажилтнуудыг дохионы хэлний сургалтад хамруулбал тэд дүлий эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн мэдээлэл өгч чадна.

Мартахгүйн тулд өөрийн эрүүл мэндийн асуудлыг цувуулан бичих



Тухайн улсад хэрэглэгддэг хэлгүй дүлий хүмүүсийн дохионы хэлийг эрүүл мэндийн нэг л ажилтан мэддэг байхад дүлий эмэгтэйчүүдийн хувьд эмнэлэгт очих илүү хялбар болно. Хэрвээ эмнэлэгтэй ойр албан ёсны дохионы хэлний сургууль байдаггүй бол тухайн эрүүл мэндийн ажилтан дүлийн иргэдийн үндэсний холбоон дээр очиж дохионы хэл заалгах, эсвэл ойролцоо амьдардаг дүлийн хүнээр заалгаж ч болох юм. Бас орон нутгийн дохионы хэлний толь бичиг байдаг бол ашиглаж болно. Бүр албан ёсны дохионы хэл ашиглахгүйгээр эрүүл мэндийн ажилтанууд дохио зангаагаар ч гэсэн нэвтрэлцэж чадна. Харилцааны ямар аргыг хэрэглэн тэдэнтэй нэвтрэлцэж болохыг дүлий эмэгтэйчүүд өөрсдөө сайн хэлж чадна. 369-371-р хуудаснаас эрүүл мэндийн холбогдолтой дохионы үгсийг үзнэ үү.

Олон нийтийн эрүүл мэндийн ажилтнууд дараах тусламжийг үзүүлж чадна

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үзүүлэхэд онцгой чадвар шаардлагатай, бас зөвхөн эмч хүн тусламж үзүүлдэг гэсэн ойлголт ихэнх улсад ажиглагддаг. Гэтэл эдгээр тусламжийн ихэнхийг нь бэлтгэгдсэн эрүүл мэндийн нийгмийн ажилтан, багш, нөхөн сэргээх төвийн ажилтан үзүүлэх боломжтой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үйлчилгээг ойртуулах

Непалын Каврэ (Kavre) хотын Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эмнэлэг, нөхөн сэргээх төвийн хөдөө орон нутгийн ажилтанууд бүх улс даяар амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тусламж үзүүлдэг. Эдгээр бэлтгэгдсэн ажилтанууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сэргээн засах эмчилгээ, булчин чангаруулах дасгал, хөндүүртэй шархыг эмчлэх зэрэг туламж үзүүлдэг. Бас түргэн тусламжийн анхны шатны тусламж үзүүлдэг учир хүүхдүүд гадуур гарахад илүү аюулгүй болсон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон нийтэд суурилсан тусламж үйлчилгээний талаар илүү дэлгэрэнгүй мэдэхийг хүсвэл *Тосгоны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд* сэдвээс үзнэ үү.

Эмнэлэг, эрүүл мэндийн төвийн барилгыг илүү хүрээмжтэй болгох зардал багатай санаанууд

Хүмүүсийг халуун дотноор хүлээн авдаг барилга байхад холдуулдаг барилга ч бас байдаг. Хэдхэн сайн чанарын зам, налуу шат, шатны бариул, ойрхон алхамтай шат, цахилгаан шат, том ариун цэврийн өрөө, давхарууд нь хальтардаггүй шалтай байхад л барилга ямар ч хүн ороход хялбар болдог нь үнэхээр гайхалтай.

Шатны бариул (эсвэл олс татах)

Барилга руу орсон замын дагуу, барилгын дотор ханыг дагуулан олс татах, эсвэл бариул суулгахад хараагүй хүмүүс, тэнцвэрээ олохдоо бэрхшээлтэй хүмүүс, муу алхдаг хүмүүст дотогш ороход нь, бас дотор ороод замаа олоход нь ихээхэн тустай.

Эрүүл мэндийн төвийн барилгын эргэн тойронд замын дагуу олс татаж, замын гадаргууг гөлгөр болгон хөвөө хашлага хийснээр хүртээмжтэй болдог. Гөлгөр тэгш гадаргуу нь харааны бэрхшээлтэй болон муу хардаг эмэгтэйчүүдэд тустай.



Эрүүл мэндийн төвийн барилгын эргэн тойронд замын дагуу олс татаж, замын гадаргууг гөлгөр болгон хөвөө хашлага хийснээр хүртээмжтэй болдог. Гөлгөр тэгш гадаргуу нь харааны бэрхшээлтэй болон муу хардаг эмэгтэйчүүдэд тустай.

Хаалга

Хаалганд бөндгөр бариулаас илүүтэйгээр доош дардаг бариул тохиромжтой. Гараа хөдөлгөхдөө муу хүмүүс хаалганы бариулыг доош нь хялбархан дарж чаддаг. Тэргэнцэр хэрэглэдэг ихэнх хүмүүст доош дардаг бариул хялбар байдаг. Ямар нэг зүйл гартаа өргөж яваа хэн ч байсан бариулыг доош нь дарж хаалгыг онгойлгох амархан байдаг.

Хаалганы бөндгөр бариулыг доош нь дардаг болгон өөрчлөхөд маш амархан. Хаалганы бариулыг намхан биетэй болон тэргэнцэртэй хүмүүст хүрэхээр доор байрлуул.




Хаалга зуурч онгойдог бол нугас руу нь тос, лааны тос, өөхөн тос хийхэд хаалга амархан онгойдог болно.

Хаалгыг онгойж хаахад тэргэнцэртэй хүн багтахар хангалттай зай үлдээх шаардлагатай. Хэрэв ариун цэврийн өрөө бусад өрөөний хаалга онгойхдоо хангалттай зай байхгүй бол хаалгыг дотогш онгойдог болгох, эсвэл талбайг арай том байхаар төлөвлөх хэрэгтэй. Зай талбай нь бага тохиолдолд гүйдэг хаалгыг бас ашигладаг.

Хаалга тэргэнцэртэй хүн орж багтахар өргөн байх шаардлагатай. Тэргэнцэр багтах хангалттай зайтай байхаас гадна тэргэнцэрийнхээ дугуйг эргүүлэхэд гар багтахар зайтай байх ёстой.

Хаалганы нугасыг сольж хаалгыг нөгөө тал руу нь онгойдог болгож болно.




Often you can change the hinges on a door so it opens the other way.

Налуу шат хийх

Эрүүл мэндийн төв, сургууль, номын сан зэрэг олон нийтийн газруудыг налуу шаттай болгосноор маш олон хүн барилгад орж гарахад хялбар болно. Налуу шатыг тэргэнцэртэй хүмүүсээс гадна алхахад бэрхшээлтэй болсон хүмүүс, гэмтэл аваад түр зуур бэртэлтэй байгаа хүмүүс налуу шатыг ашигладаг.



Энэ налуу шатны урт өндрөөсөө 4 дахин урт байна. Ийм харьцаатай налуу шат зай нь ойр боловч хэт огцом учраас ихэнх хүмүүсийн хувьд ашиглахад бэрхшээлтэй байдаг.



Налуу шатны урт нь өндрөөсөө 8-12 дахин урт байвал тохиромжтой байдаг. Энэ шатны урт өндрөөсөө 12 дахин урт байна. Ийм налуу ямар ч тэргэнцэртэй хүнд ашиглахад хялбар байна.

Ариун цэврийн өрөө



Хэрэв та тэргэнцэр дээр суудаг бол ариун цэврийн өрөө дотор нь ороод эргэх, тэргэнцэрээсээ суултуур руу шилжин суух хангалттай зайтай байх ёстой. Жорлонгийн суултуурын өндөр нь таны тэргэнцэртэй ижил, эсвэл арай нам байвал дамжиж суухад хялбар байна. Хэрэв жорлонд суултуур байдаггүй гишгүүртэй бол, суултуур нь хэт намхан бол та гарын бариултай, нээгддэг энгийн суултуур хийж чадна. Бас та хананд нь бариул, хөшүүр байрлуулбал унах аюулгүй болно (123-р хуудаснаас харна уу.)

Эмнэлгийн ор

Зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ч биш бусад олон хүн эмнэлэгийн орон дээр гарахад хэцүү байдаг гэсэн гомдол гаргадаг. Эдгээр орнууд нь хүмүүсийн гэртээ хэрэглэдэг орноос ихэвчлэн өндөр байдаг. Эмч эмнэлэгийн ажилтануудад намхан орон дээр хэвтэж байгаа өвчтөнд тонгойн эмчилгээ үйлчилгээ үзүүлэхэд хялбар байдаг байж болох юм.



Гэтэл өвчтэй хүмүүст болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ор руу мацах маш хүнд байдаг. Бас орнууд ихэвчлэн дугуйтай байдаг тул орон дээр гарахаар мацаж байгаа хэн нэгнийг оролдож байх зуур хөдлөх аюултай.



Хэрэв эмнэлэгийн зарим ор нь дугуйгүй, эсвэл намхан байвал хүмүүс өөрт хамгийн сайн тохирох орыг сонгох боломжтой болно.

Эмнэлгийн ажилтнуудад:

Хөгжлийн бэрхшээлийн талаар судал

Эмч, эмнэлгийн ажилтнууд ихэвчлэн хөгжлийн бэрхшээлгүй хүмүүсийг эмчлэх талаар сургагдсан байдаг. Хөгжлийн бэрхшээлийн талаарх асуудал тэдний авсан боловсролын маш багахан хэсгийг эзэлдэг. Эмч нар магадгүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөгжлийн бэрхшээлийг л “эмчлэхийг” оролдохоор тэдэнтэй холбогддог байх.

Харин эрүүл мэндийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлийн талаар илүү ихийг сурч мэдэх хэрэгтэй. Тэд хөгжлийн бэрхшээл бүр ямар онцлогтой болох, тухайн бэрхшээл нь эмэгтэйг жирэмслэх, хөгшрөх зэрэгт хэрхэн ямар нөлөөлөл үзүүлж болох зэрэг онцлогуудыг мэдсэн байх хэрэгтэй.

Эрүүл мэндийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлийн талаар судлах хамгийн сайн арга бол сургалтын хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг оролцуулах. Эрүүл мэндийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдээс суралцсанаар тэдний туршлагыг мэдэхээс гадна тэдэнд ээлтэй үйлчилгээг хэрхэн сайн үзүүлэх боломжтой вэ гэдгийг олж мэдэх зэрэг олон талын ач холбогдолтой.

Та цээжээ үзүүлье гэж хэлсэн чинь их сайн юм боллоо. Та астматай юм байна. Тэгээд л та амьсгаадаад байсан байна. Энэ таны хөгжлийн бэрхшээлтэй огт хамаагүй.



Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй танд өөрийн эрүүл мэндийн байдлын талаар юу хэлж байгааг анхааралтай сонс. Тэгээд дараа нь тухайн эмэгтэйн эрүүл мэндийн асуудал нь хөгжлийн бэрхшээлтэй нь холбоотой юу? үгүй юу? гэдэг талаар эмэгтэй өөрөө юу гэж бодож байгааг асуу.

Эрүүл мэндийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдээс суралцсан нь

Уганда улсын Эрүүл мэндийн яамнаас эмнэлэгт эх баригч хийдэг болон болон уламжлалт аргаар эх баригч хийдэг хүмүүстэй ярилцан ажлаа хийхэд нь тэдэнд ямар мэдээлэл хэрэгтэй байгаа талаар асуусан байна. Гэтэл хэд хэдэн хүн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд яаж туслах талаар мэдэх хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн.

Харин өнөөдөр Уганда улсын Эрүүл мэндийн яам хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаар ойлголт мэдээлэл өгөх сургалт семинарыг зохион байгуулж эхэлсэн. Энэ сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд өөрсдөө удирдан зохион байгуулдаг.

Тэд эрүүл мэндийн ажилтнуудад өөрийн мэдлэг туршлагыг хуваалцахаас гадна хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйг эмчлэх хамгийн сайн арга замыг олоход нь эмч нарт хэрэгтэй асуултад хариулдаг байна. Ийнхүү хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, эрүүл мэндийн ажилтнууд бие биенээсээ суралцах боломжтой болсон.



Дараагийн долоо хоногт Хараагүй эмэгтэйчүүдийн холбоо яриа хийнэ.

Ашгүй дээ! Хараагүй эмэгтэйчүүд гэр бүл төлөөлөлтийн талаар мэдээлэл авахад нь яаж туслахаа мэдэхгүй байсан юм.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээг бий болгох

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй эрүүл мэндийн асуудалтай болоод эмнэлэгт ирэхэд нь та түүнийг бусад эмэгтэйчүүдийн нэгэн адил эмэгтэй хүн гэдгийг нь санаж хүлээн авах хэрэгтэй. Эхлээд түүнээс “яагаад” өөрт чинь хандах болсон, та түүнд яаж туслах вэ? гэдгийг нь асуу. Тухайн үйлчлүүлэгч эмэгтэйд хөгжлийн бэрхшээлтэй нь холбож хүлээн авах хэрэггүй.

Танаас асуулт асуух боломжийг олго. Тэгэх юм бол эмэгтэй өөрөө танд хүндрэлтэй байгаа асуудлаа хэлээд өгнө. Түүний бодлыг хүндэтгэн үзэх ёстой. Энэ бүхний дараа эмэгтэй эрүүл мэндийн байдал нь ямар байгаагаа сайн ойлгож чадах бөгөөд түүнийг эмчлэх оновчтой шийдвэр гарсан гэдгийг ч мэдэж авна. Эмэгтэйд тайвширтал хүлээн ярихгүй байгаа асуудал, асуугаагүй асуултаа асуух цаг гарга. Энэ нь түүний айдсыг дарна. Заримдаа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд санааг нь зовоож байгаа гол асуултаа асуух зориг дутдаг. Эсвэл хувийн нууцыг нь хадгалах орчин биш гэж үзвэл санаагаа тодорхой илэрхийлэхгүй. Гэхдээ та хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн айдсаа багасгахад нь, өөртөө итгэлтэй болоход нь, тэдэнд хэрэгтэй эмчилгээ үйлчилгээний мэдээллийг авахад нь тусалж чадна.

Та ажлаа яаж хийвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст таатай байхыг тэднээс өөрсдөөс нь асуу. Тэдний асуусан асуулт бүхнийг та хариулж чаддаг байх албагүй. Та мэдэхгүй бол үнэнээ хүлээж хэрэгтэй байгаа мэдээллийг нь олж өгөхийг амлах нь хэвийн үзэгдэл.



Миний мөрөөдлийн эмнэлэгт эрүүл мэндийн ажилтан нь: “Чиний хөгжлийн бэрхшээлтэй холбоотой миний мэдэх ёстой ямар нэгэн зүйл байгаа юу? Таны хөгжлийн бэрхшээл эрүүл мэндэд чинь яаж нөлөөлдгийг хэлж өгөөч.” гэж асуух байсан.

Хүндлэл

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйн эрүүл мэндэд санаа тавьдаг хэн ч бай түүнтэй хэрхэн эелдэг зөөлөн аргаар харьцах талаар мэддэг байх ёстой. Тэдэнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байгаа хэн ч бай үргэлж хүндэтгэлтэй хандах хэрэгтэй. Харамсалтай нь хүмүүс үүнийг мартдаг тул заримдаа сануулж байх. Тухайн эмэгтэйдгээс асуудал юунаас болж үүссэн болохыг, тэр өөрөө энэ асуудлыг хэрхэн шийдвэрлүүлэхийг хүсч байгааг нь асууж түүнийг чөлөөтэй ярихад нь урам зориг өгөх хэрэгтэй. Ийм аргаар эрүүл мэндийн ажилтнууд олон төрлийн хөгжлийн бэрхшээлийн талаар ойлгох чадварт суралцана. Хамтран ажиллах нь зөрчлийг багасгаж хамгийн сайн үр дүнг авчирдаг!



Эмч, эмнэлгийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлийн талаар дутуу дулимаг ойлголттой байх юм бол тэдний хандлага хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйд ичгэвтэр байдалд оруулна.

Онцлог хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйд туслах нь

Харааны бэрхшээлтэй болон хараагүй эмэгтэй

- Онцгой яаралтай зүйл л биш бол өөрийгөө танилцуулахгүй эмэгтэйн биед хүрч болохгүй.
- Эмэгтэй таныг ердөө ч харахгүй гэж бодож болохгүй.
- Өөрийнхөөрөө түүнтэй ярилц.
- Хэрэв эмэгтэй таяг хэрэглэдэг бол хэлэлгүйгээр зүгээр л түүнээс холдуулж болохгүй.
- Эмэгтэйдээс холдон явахдаа баяртай гэж хэлэлгүйгээр бүү орхи.

Намайг хаана байгааг танилбарлан үзлэгийн ширээ, эсвэл сандал руу хүргэж өгөөч. Өрөөнийголд намайг орхиж болохгүй шүү.



Сонсголын бэрхшээлтэй болон сонсголгүй эмэгтэй



Ярилцахдаа миний хэлмэрч рүү, эсвэл надад хэлмэрчилж байгаа миний гэр бүлийн хүн рүү биш над руу хар.

- Ярилцаж эхлэхээсээ өмнө анхаарлыг нь өөртөө хандуул. Хэрэв тань руу хараагүй байвал мөрөн дээр нь зөөлөн хүр.
- Ярихдаа хашгирах, дуугаа өндөрсгөх хэрэггүй.
- Эмэгтэй рүү эгц харж амаа ямар нэгэн зүйлээр бүү халхал.

- Түүнтэй харилцах хамгийн тохиромжтой ямар арга байгааг өөрөөс нь асуу.

Хөдлөх эрхтний бэрхшээлтэй эмэгтэй

- Эмэгтэйн хүлээн авах чадвар сул байна гэж тааварласан дүгнэлт хийж болохгүй.
- Боломжтой бол түүний нүдний түвшинтэй зэрэгцэн суу.
- Эмэгтэйн зөвшөөрөлгүйгээр таяг, тэргэнцрийг бүү хөдөлгө.
- Хэрэв эмэгтэй тэргэнцэртэй бол түүний зөвшөөрөлгүй тэргэнцэрт нь хүрэх, налах зэрэг үйлдэл гаргаж болохгүй.

Миний асран хамгаалагч, эсвэл гэр бүлийнхэнтэй минь биш нагтай шууд ярилц.



Ярих чадвар сул эмэгтэй

- Эмэгтэйн яриа удаан, ойлгоход хүндрэлтэй байсан ч гэсэн тэр оюун ухааны хомсдолтой гэсэн үг биш.
- Та ойлгоогүй зүйлээ түүнээс дахин хэлж өгөхийг хүсэх хэрэгтэй.
- “Тийм”, “үгүй” гэж хариулах боломжтойгоор асуулт тавь.
- Эмэгтэйд өөрт тулгарсан асуудлаа ярихад нь хангалттай цаг гарга. Тэвчээртэй ханд.



Хэрэв миний хэлснийг ойлгоогүй бол ойлгосон дүр бүү үзүүл.

Оюуны хомсдолтой эмэгтэй

- Богино өгүүлбэрээр энгийн үг хэллэг ашиглан ярилц.
- Тэвчээртэй, эелдэг ханд. Түүнтэй хүүхэд шиг харьцаж болохгүй.

Надад хэсэг хэсгээр мэдээлэл өгч шавардлагатай бол даатан хэлээрэй.



Өөрчлөлт хийх

Эмнэлгийн ажилтантай хамтран эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулахад ашиглаж болох хэдэн саналыг танд толилуулъя. Дараах ажлуудыг хийж болно:

- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд эрүүл мэндийн чанартай үйлчилгээг авахад хүндрэл учруулж байгаа боломж, хүртээмж, хандлагын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулж чадах ажлуудыг тодорхойл
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд гардаг саад, эмэгтэй хүн бүрийн итгэл найдварыг бий болгож чадсан өөр өөрсдийнхөө туршлагаа бусадтайгаа хуваалцах бүлгийн ярилцлага зохион байгуул.

Алхам 1. Хүн бүхэнд ямар нэгэн санаа байж л таараа

Хүн бүхэнд бусдын төлөө хийж чадах зүйл байдаг тул өөрийн хамгийн сайн хийж чадах зүйл, эсвэл түүний бахархалыг яриулж хүн бүрийг аятай таатай байхад нь тусал. (Хэрэв эмэгтэй өөрөө ярихыг хүсэхгүй бол хэнийг ч албадаж болохгүй) Жишээлбэл:



Кранти бол маш сайн тогооч



Мария эгч дүүсээ эвтэй байлгаж чаддаг.




Раня бол маш сайн эх баригч бөгөөд зуу зуун хүүхдийг эх барьж төрүүлсэн.



Адетоун бол чадварлаг үлгэрч. Түүний үлгэр ярихыг гэр бүлийнхэн нь болон ойр орчмын хүүхдүүд сонсох дуртай.

Алхам 2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар туршлага солилцох

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй эрүүл мэндийн чанартай сайн тусламж үйлчилгээг авахад нь саад болдог ямар нэгэн зүйлтэй тулгарч байсан, эсвэл харж байсан талаараа ярьж өгөхийг хүн бүрээс асуу. Эмэгтэйчүүдийн тодорхойлон хэлж байгаа хүндрэлтэй асуудлуудыг маш товч жагсаан бич.

**Алхам 3. Дүрд орж тоглох замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгардаг бэрхшээлээс суралцах**

Тэдний жагсаасан хүндрэлтэй асуудлыг хүн бүрт илүү гүнзгий ойлгуулахын тулд жүжигчилсэн тоглолтын аргыг ашиглах. Эрүүл мэндийн ажилтнууд, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдээс бүрдсэн хэд хэдэн баг болгон хуваах.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй эрүүл мэндийн чанартай сайн үйлчилгээ авахад нь саад тулгарч байгаа тухай жүжиг бэлдэх хугацаа өг. Оролцогч бүрт урам зориг өгөөрэй.



Жүжигчилсэн тоглолт

Амьдралын бодит асуудал, нөхцөл байдлыг хүмүүст ойлгуулах хамгийн шилдэг арга бол жүжигчилсэн тоглолт хийх юм. Жүжгийнхээ талаар багаараа ярилцах үед эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд нөлөөлж байгаа хандлага, уламжлал, дадал зуршлын талаар ярилцах боломжтой болдог. Жүжигчилсэн тоглолт нь тухайн асуудлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, сонголт хийх зэрэгт ихээхэн тустай.


Жүжигчилсэн тоглолт хөгжилтэй боловч маш нухацтай байх ёстой. Дүр болон үйл явдал нь хэтрүүлэгтэй байж болох ч үнэнд ойр, амьдралд нийцсэн байх ёстой. Жүжигчилсэн тоглолт нь урьдчилан бэлдэж үгээ цээжлэх шаардлагагүй богинохон хэлбэрээр байж болно.



(жүжигчилсэн тоглолт, театрын боловсролын талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг *Эрүүл мэндийн ажилтнуудын мэдлэгт хэсгээс харна уу*, 14, 27-р бүлэг.)

Боломжит жүжигчилсэн тоглолтууд

Багууд өөрсдөө санаагаа олоход хүндрэлтэй байвал та дараах сэдвүүдийг санал болгож болох юм. Үүнд:



Жүжигчилсэн тоглолт дуусангуут “жүжигчдийг” хүмүүс рүү харж зогсохыг хүс. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй эрүүл мэндийн чанартай сайн үйлчилгээ авахад нь тулгардаг хүндрэлийн талаарх тэдний ойлголтыг гүнзгийрүүлэх жүжигчилсэн тоглолтын талаар асуух асуултыг нь бусад багуудаар асуулгах байдлаар явуулна.

4-р алхам. Эрүүл мэндийн төвд зочил

Багууд эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжтэй байдлын талаар ерөнхий саадуудыг тодорхойлсоны дараа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд тохиолддог хүндрэлтэй шалтгаануудыг



Асуудлыг багавраа хэлэлцэх нь ганц нэгээрээ бодохоос илүү нухацтай хандахад хүргэдэг. Хэсэг хугацаанд хоорондоо ярилцан хэн нь багаа төлөөлөн ярих, юу ярихаа шийдэх хэрэгтэй. Аялал хийх зөвшөөрөл авахад та бүхэнд хугацаа хэрэгтэй байж магадгүй.

ойроос харахаар орон нутгийн эрүүл мэндийн төвд зочилж очиж болно. Хэрэв хүний тоо хангалттай бол баг бүрт эрүүл мэндийн ажилтныг хуваарилан хоёр баг болон хуваагдаж нэг болон түүнээс дээш эмнэлэгт очиж үзэх хэрэгтэй (хэрэв боломжтой бол тухайн багт байгаа эрүүл мэндийн ажилтны ажилладаг эмнэлэгт очихгүй байхыг хичээгээрэй). 1-2 эмэгтэйгээр тэмдэглэл хөтлүүлэн тухайн багийн олсон ямар нэгэн хүндрэлтэй асуудал, бэрхшээлийг бичүүлнэ. Мөн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд хэрэгтэй байж болох сайн туршлага болохуйц ямар нэгэн зүйл олвол түүнийгээ бас тэмдэглэлдээ бичиж авахыг хүсээрэй.

Эрүүл мэндийн төвд зочлох аялалыг бие биедээ хэрхэн тусалж чадах, бэрхшээлийг даван туулах болон бие биенийхээ чадварыг ашиглан хамтран ажиллах тэдний жишээг гаргах сайхан боломж болгож болно. Жишээлбэл, тэргэнцэртэй эмэгтэйчүүд харааны бэрхшээлтэй нэгэндээ хөтөч болж чадна, харааны бэрхшээлтэй эмэгтэй бусдын дэмжлэгтэйгээр алхдаг нэгэндээ тусалж чадна.

5-р алхам. Эрүүл мэндийн төвөөр явахдаа та юу олж харсан бэ?

Аялалаас эргэн ирээд багууд өөрсдийн олж харсан бэрхшээлүүд болон хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд хэрэгтэй байж болох сайн туршлагын талаар ажигласан тэмдэглэсэн зүйлсээ тодорхойлно. Мөн бусад багийнханаас эмнэлгийн дарга, ажилтнууд тэдэнтэй хэрхэн харьцаж байсныг асуу. Өөрсдийн олж харсан зүйлсээ зураг жагсаалтаар харуулж болно.



Эрүүл мэндийн төвүүдийн мэдээллийг харьцуулж үз. Багууд ижил төстэй хүндрэлийг олж харсан байна уу?

6-р алхам. Аль асуудал нь хамгийн чухал вэ?

Эрүүл мэндийн төвүүдээр явж үзээд олж харсан асуудлуудаас тэдний бодлоор аль нь хамгийн гол өөрчлөх зүйл байсан, эсвэл тэд алийг нь хамгийн түрүүнд өөрчлөхийг хүсч байгаа талаар ярилц. Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулахад төлөвлөгөө, цаг хугацаа хэрэгтэй. Магадгүй танай багийнхан жагсаалтыг хараад алийг нь хурдан өөрчилж чадах, алийг нь өөрчлөхөд хугацаа шаардагдах талаар судлахыг хүсч болох юм. Яагаад энэ асуудлыг чухал гэж үзэн сонгож авсан, хэрэв тэдгээр асуудлууд шийдэгдэн нөхцөл байдал дээрдвэл тэд ямар өөрчлөлт гарна хэмээн хүсч найдаж байгааг асуу.



7-р алхам. Сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө

Ажлын баг нэгэнт хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй эрүүл мэндийн чанартай үйлчилгээг авахад саад болж байгаа 1, 2 асуудлыг сонгосон тул тэдгээр асуудлыг шийдвэрлэх ажлын төлөвлөгөөн дээр ажиллах хэрэгцээтэй болно.

Тэд асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар өөр өөр аргуудыг ярилцан, энэ өөрчлөлтийг хийхэд тэдэнд хэн тусалж чадах талаар бодохыг тэднээс хүсэх хэрэгтэй. Энэ өөрчлөлтийг хийхэд шаардлагатай алхмуудыг тооцоолж хэн аль алхамыг хариуцахаа төлөвлөх хэрэгтэй. Үүний дараа ажилдаа орох л үлдлээ!

